



Шинжээчийн багийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: **Технологийн дээд сургууль**
Хөтөлбөрийн нэр: **Хүнс үйлдвэрлэлийн технологи**
Индекс: **072104**

Шинжээчийн баг:

Ахлагч:	Т. Амаржаргалан	Инженер технологийн дээд боловсролын төслийн ахлах зөвлөх, доктор
Гишүүд:	Б. Буянчимэг	Хөдөө аж ахуйн их сургууль, Инженер технологийн сургуулийн “Хөдөө аж ахуй, Хүнсний инженерчлэл”-ийн тэнхимийн ахлах багш, доктор
	Г. Оюун	Хүнсний эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн “САМО” институтын гүйцэтгэх захирал
	Э.Баярмаа	Шинжлэх ухаан технологийн их сургууль, Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн чанарын менежер, доктор

2022.12.26

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нартай хийх уулзалт

II. Оюутан, суралцагчидтай хийх уулзалт

III. Ажил олгогчидтой хийх уулзалт

IV. Төгсөгчидтэй хийх уулзалт

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

- БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
- БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
- БНБД	Барилгын норм ба дүрэм
- БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
- БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
- БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
- БШУ-ны сайд	Боловсрол шинжлэх ухааны сайд
- ДБСБ	Дээд боловсролын сургалтын байгууллага
- ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
- Кр	Кредит
- МБОС	Мэргэжлийн боловсрол олгох сургалт
- МУ	Монгол улс
- МУИС	Монгол улсын их сургууль
- МҮОНТ	Монголын үндэсний олон нийтийн телевиз
- МХЕГ-ын ХАБУЛ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори
- МХХАХ	Монголын хөргөлт, агааржуулалтын холбоо
- МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
- НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
- НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
- ОХУ	Оросын холбооны улс
- ОУА	Озоны үндэсний алба
- ӨМӨЗО	Өвөр монголын өөртөө засах орон
- ӨМХААИС	Өвөр монголын хөдөө аж ахуйн их сургууль
- ТББ	Төрийн бус байгууллага
- ТДС	Технологийн дээд сургууль
- ТТДС	Техник технологийн дээд сургууль
- УИХ	Улсын их хурал
- ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн холбоо
- ХАА-н тэргүүн	Хөдөө аж ахуйн тэргүүн
- ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
- ХАБ	Хөдөлмөрийн аюулгүй байдал
- ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй
- ХЗЗ	Хөдөлмөрийн зах зээл
- ХТПК	Хүнс, технологийн политехник коллеж
- ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
- ШУТ-ийн төсөл	Шинжлэх ухаан технологийн төсөл
- ШУТС	Шинжлэх ухаан, технологийн сан
- ШУТИС-ийн ҮТС	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Үйлдвэрлэл технологийн сургууль
- ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
- ЭМШУИС	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль
- ЭМЯ	Эрүүл мэндийн яам

Англи үгс

- APACC Asia Pacific Accreditation and Certification Commission
- GHP Good Hygiene Practices
- GMP Good Manufacturing Practices
- HACCP Hazard Analysis Critical Control Point
- ISO International Organization for Standardization
- PDCA Plan Do Check Act
- STEEP Strengths, Weaknesses, Opportunities, Threats
- SWOT Social, Technological, Economic, Environmental, Political

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр	Технологийн дээд сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр	“Хүнс үйлдвэрлэлийн технологи”	
Индекс	072104	
Шинжээчид	1. Ахлагч: Т. Амаржаргалан 2. Гишүүн: Б. Буянчимэг 3. Гишүүн: Г. Оюун 4. Гишүүн: Э.Баярмаа	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Ж.Мөнхбилэг - БМИҮЗ-ийн магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
		Шинжээчийн багийг томилох
	2022.12.01	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	2022.12.01-02	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	2022.12.09	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2022.12.15-16	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	2022.12.26	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2022.12.27	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	2022.12.28	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2022.12.29	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
		Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Технологийн дээд сургууль нь 1965 онд мах, сүү, талх чихэр, нарийн боов, гурилын үйлдвэрийн өндөр мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх 2 жилийн сургалттай, 400 суралцагсадтай “Хүнсний үйлдвэрийн техник мэргэжлийн сургууль” нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба 1991 онд “Шаталсан сургалттай Хүнсний мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв”, 1998 онд “Хүнсний технологийн сургууль”, 2000 онд “Хүнсний технологийн коллеж”, 2010 оноос “Технологийн дээд сургууль” болон өргөжиж, сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн хэв шинжит сургууль болон хөгжиж байна. Хүнс, хоол үйлдвэрлэл, зочлох үйлчилгээ болон бусад чиглэлээр шаталсан сургалтын хөтөлбөрөөр мэргэжилтэй ажилтан, техникч, технологич 30000 гаруйг бэлтгэн гаргасан байна.

БСШУ-ны сайдын 2014 оны А/78 тоот тушаалаар “Хүнсний үйлдвэрлэлийн технологи” (D540800) мэргэжлийг “Хүнсний инженерчлэл” (D072101) хөтөлбөрийн хүрээнд нэгтгэж, дотроо 3 чиглэлээр төрөлжин өдөр, оройн ангиар бакалаврын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэж ирсэн байна.

БШУ-ны сайдын 2022 оны “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/ индекс шинэчлэн батлах тухай” А/160 тоот тушаалаар “Хүнсний инженерчлэл” хөтөлбөрийг задалж 3 чиглэлээр тусдаа тусгай зөвшөөрөл олгосон ба “Хүнс үйлдвэрлэлийн технологи” (072104) бакалаврын сургалтын хөтөлбөрөөр үргэлжлүүлэн сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус сургууль эрхэм зорилгынхоо хүрээнд “Ажил амьдралд бэлтгэгдсэн мэргэжилтэн бэлтгэх”-д чиглэсэн үр дүнд суурилсан боловсролын зарчмаар хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Хүнс үйлдвэрлэлийн технологи хөтөлбөрийг Хүнсний технологийн тэнхим хариуцан ажилладаг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн 13 багш, сургалтын менежер, химич, лаборант нийт 16 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж байна.

Багш нарын 7.7% нь профессор, 30.8% нь дэд профессор, 61.5% нь ахлах багш байна. Нийт багш нарын 46% нь докторын зэрэгтэй байна. Мэргэжлийн хичээл заадаг, махны технологи, хүнсний технологи, хими, биотехнологи зэрэг чиглэлээр эрдмийн зэрэг (Ph.D)-тэй багшийн тоо нэмэгдсэн.

Багш нарын эрдэм судлалын ажил, шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх ажлыг дэмжих хүрээнд инновацын төсөл 2, аж ахуйн нэгжийн захиалгат төсөл 2, шинжлэх ухаан технологийн 2 төслийг гүйцэтгэж үр дүнг хүлээлгэн өгсөн байна

Сургалтын хөтөлбөр нь "Амьтан, ургамлын гаралтай хүнсний түүхий эдийг боловсруулж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх орчин үеийн техник, технологийг эзэмшиж, үйлдвэрлэлийн процессыг оновчтой зохион байгуулах, хүнлэг, энэрэнгүй ёсыг дээдэлдэг, мэдлэгээ чадвар болгон ашиглах мэргэжлийн бүтээлч, шинжлэх ухаанч сэтгэлгээтэй, бакалаврын зэрэгтэй мэргэжилтнийг бэлтгэх" зорилготой. Үндэсний болон олон улсын нийтлэг чадамжуудыг эзэмшсэн хөтөлбөрийн зорилгод нийцсэн мэргэжилтэн бэлтгэх төгсөгчийн загварийг тодорхойлсон байна.

Сургалтын хөтөлбөр нь нийт 130 багц цагийн хичээлийг 4 жилийн хугацаанд судлах сургалтын төлөвлөгөөтэй, үүнээс 30.9% нь ерөнхий суурь, 23.9% нь мэргэжлийн суурь,

45.2% нь мэргэшүүлэх хичээлүүд байна. Сургууль нь шаталсан сургалтын тогтолцоотой, өмнөх түвшний амжилттай төгсөгчидөөс элсүүлэн сургадаг.

Хүнс үйлдвэрлэлийн технологи хөтөлбөр 2012 онд 5 жилийн хугацаатай анх магадлан итгэмжлэгдсэн бөгөөд шинжээчдийн өгсөн зөвлөмжийн дагуу БНСУ-ын “Кореа” их сургууль, “Юнгнам” их сургууль, “Өмнөд Филиппиний шинжлэх ухаан технологийн их сургууль”, Өмнөд Африкийн “Тшвани” технологийн их сургуулийн ижил төстэй мэргэжлийн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөтэй бүтэц, хичээлийн агуулга, судлах багц цагийн үзүүлэлтээр харьцуулан судалж бенчмарк хийсэн.

2017-2022 он хүртэлх хугацаанд нийт 107/27 төгсөгчийг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэсэн.

Сургуулийн зүгээс сургалтын материаллаг баазыг өргөтгөх, мэргэжлийн ном, сурах бичгийн хангамжийг нэмэгдүүлэх, лабораторийн чадавхыг бэхжүүлэх, суралцагчдын сурлагын чанарыг дээшлүүлэх, төгсөгчдийн мэдлэг чадварыг сайжруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг.

Номын сангийн орчин нөхцөл, үйлчилгээг сайжруулан, фондыг баяжуулалт хийсэн. Цайны газар нь зохих тохижилт, сайжруулалтыг хийж, нэг ээлжиндээ 40 хүнд үйлчлэх хүчин чадалтай, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд үйлчилгээ явуулж байна.

Тус сургуулийн барилга байгууламж нь БНБД 31.03.03-д нийцсэн, давхар бүрд ариун цэврийн өрөөтэй, хүрэлцээ сайтай байна.

Оюутан солилцоогоор дадлага хийх боломж бүрдүүлэхэд анхаарч “Олон улсын дадлагажигч оюутан” хөтөлбөр хэрэгжүүлж оюутнууд Япон улсад 1 жилийн хугацаатай цалинтай дадлага хийж байна.

Оюутнуудад чанарын хяналтын олон улсын стандартуудыг таниулах хүрээнд тус сургуулийн сургалт дадлагын түшиц бааз болох мах, сүү боловсруулах үйлдвэрт 2019 онд НАССР тогтолцоог амжилттай нэвтрүүлсэн ба дадлага сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн
- Засгийн газрын 2020 оны 70-р тогтоол
- Засгийн газрын 2019-2023 онд баталсан “Эрүүл хүнс-Эрүүл Монгол” үндэсний хөтөлбөр
- “Хүнс үйлдвэрлэлийн технологи” хөтөлбөрт хийсэн STEEP шинжилгээ /2022/
- БНСУын Кореа их сургууль, Филиппины ШУТИС, дотоодын ШУТИС-ийн хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмарк /2021-2022/
- Төгсөгчдийн сэтгэл ханамж, эрэлтийн судалгаа
- Оролцогч ба сонирхогч талуудын эрэлт хэрэгцээн дээр суурилан хөтөлбөрийн шинэчлэн сайжруулсан баримт
- Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл

Онцлог зүйл:

- Хүнсний боловсруулах үйлдвэрүүдийг хөгжүүлэх, аюулгүй, тэжээллэг хэрэгцээт хүнсээр хангах, экспортын чиг баримжаатай брэндийг бий болгох зэрэг улс орны бодит төлөвлөгөөтэй хөтөлбөрийн үйл ажиллагаа уялдсан байна.
- Гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж лаборатори, дадлагын газар, сургалтын түшиц газар болох мах, сүүний үйлдвэрийг байгуулж суралцагчдыг бодит орчинд сургаж байна.
- 2015 онд байгуулагдсан биохимийн итгэмжлэгдсэн лаборатори нь төрөл бүрийн хүнсний технологийн болон чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлох орчин үеийн өндөр мэдрэмжит багаж төхөөрөмжүүдээр тоноглогдсон ба 2017, 2020 онуудад тус тус магадлан итгэмжлэгдсэн байна.

Анхаарах асуудал:

- Ажил олгогчдын эрэлт хэрэгцээг тодорхой судлах

Дүгнэлт:

Монгол улсын урт, дунд хугацааны зорилтууд, хүнсний салбарын хэтийн хөгжилд нийцүүлэн Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон бөгөөд олон улсын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулсан шинжилгээ хийж, төлөвлөлтөндөө тусгасан байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрт оролцогч талуудын санал асуулгыг тогтмолжуулах, эрэлт хэрэгцээнд суурилан хөтөлбөрийн сайжруулалтын байнга хийдэг байх

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- “Эрүүл хүнс-Эрүүл Монгол” үндэсний хөтөлбөр
- “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн
- Технологийн дээд сургуулийн Алсын хараа, Эрхэм зорилго (2019-2023 он)
- Хүнсний үйлдвэрлэлийн технологи хөтөлбөрийн зорилго
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг ур чадварууд хөтөлбөрийн зорилтуудын хоорондын уялдаа холбоо
- Хөтөлбөрөөр төгсөгчийн, үндэсний болон олон улсын нийтлэг мэдлэг, чадамжуудыг эзэмшүүлэхээр тодорхойлсон “Төгсөгчийн загвар”

Онцлог зүйл:

- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадварын талаар мэргэжлийн ... “хүнсний түүхий эдийг боловсруулж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх орчин үеийн технологийн мэдлэгтэй, үйлдвэрлэлийн процессыг оновчтой удирдан зохион байгуулах чадвартай, хүнлэг, энэрэнгүй. "гэдэг ур чадвараас гадна" мэргэжлийн ёс зүйтэй байна." гэж томъёолон оруулсан байна.
- Дээрх мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшсэнээр хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгж, бусад хүнсний чиглэлийн төрийн болон төрийн бус салбарт хөрвөн ажиллах боломжийг хангах давуу талтай байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлоход сонирхогч талуудын оролцоо тогтмол бус

Дүгнэлт:

Сургалтын хөтөлбөрийн зорилгыг “Амьтан, ургамлын гаралтай хүнсний түүхий эдийг боловсруулж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх орчин үеийн техник, технологийг эзэмшиж, үйлдвэрлэлийн процессыг оновчтой зохион байгуулах, хүнлэг, энэрэнгүй ёсыг дээдэлдэг, мэдлэгээ чадвар болгон ашиглах мэргэжлийн бүтээлч, шинжлэх ухаанч сэтгэлгээтэй, бакалаврын зэрэгтэй мэргэжилтнийг бэлтгэхэд оршино” гэж тодорхойлсон нь хүнс үйлдвэрлэлийн салбарын төрийн бодлого, “Ажил амьдралд бэлтгэгдсэн мэргэжилтэн бэлтгэх” сургуулийн эрхэм зорилго, алсын хараанд бүрэн нийцэж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, төгсөгчийг мөшгөх судалгааг тогтмолжуулах, оролцоог сайн хангах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БШУС-ын 2014оны А/174 тушаал “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”
- БШУС-ын 2022 оны А/160 тушаал “Мэргэжлийн чиглэл/хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэх тухай”
- Тус сургуулийн Эрдмийн Зөвлөлөөр батлагдсан “Хүнсний үйлдвэрлэлийн технологи” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр
- ХТПК-д техникийн боловсрол эзэмшсэн суралцагч бакалаврын хөтөлбөрт дэвшин суралцах “Оюутан элсүүлэх журам”
- Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн талаар баримт материал

Онцлог зүйл:

- Шаталсан сургалтын тогтолцооны хүрээнд, мэргэжлийн чиглэлээр техникийн боловсрол эзэмшсэн иргэдийг Дээд боловсролын дүрэм, журамд нийцүүлэн элсүүлж, өдөр, оройн хэлбэрээр сургаж байгаа нь онцлог байна. Анхан шатнаас нь эхэлж мэргэжлийн бодит, практик ур чадвар эзэмшсэн, мэргэжлийн зөв дадал, мэдрэмжтэй элсэгчид бакалаврын түвшний боловсрол олгож байгаа нь өндөр ур чадвартай, сайн мэргэжилтэн бэлтгэх, хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх давуу тал үүсгэж байна.

Дүгнэлт:

Тус хөтөлбөрийг боловсруулахдаа дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагад нийцүүлсэн бөгөөд гадаад дотоодын ижил мэргэжлийн хөтөлбөрүүдтэй харьцуулж, дүн шинжилгээ хийсэн байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 1. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ:

“Хүнс үйлдвэрлэлийн технологи” мэргэжил нь Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлд хамаардаг бөгөөд энэ чиглэлийн бакалаврын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэх хэрэгцээ шаардлага байна.

Технологийн дээд сургууль тус бакалаврын хөтөлбөрийг улс орны урт, дунд хугацааны зорилтууд, үндэсний болон олон улсын зах зээлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлсэн байна. Төгсөгчийн ажлын байр эрэлт ихтэй, ажил олгогчийн сэтгэл ханамж сайн байна. 2012 онд хийгдсэн анхны магадлан итгэмжлэлийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн, хөтөлбөрийн сайжруулалт үе шаттайгаар хийгдсэн байна.

Хөтөлбөрийн төлөвлөлт, баримт бичгийн бүрдэл, боловсруулалт бүрэн, БШУЯ-аас тавигддаг нийтлэг шаардлагуудын хангасан байгаа тул 1-р шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан гэж үзэж байна.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- ТДС-ийн захирлын холбогдох тушаалууд
- Сургалтын төлөвлөгөө
- Заавал судлах хичээлүүдийн онол, дадлагын хичээлүүдийн эзлэх хувь, кредит цагийг тооцсон байдал
- Хичээлүүдийн хэвтээ болон босоо тэнхлэгийн залгамж холбооны зураглал
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн матриц тодорхойлсон байдал
- Хичээлийн стандарт хөтөлбөрүүд
- Суралцагчийн кредит цагийн ачааллыг тооцсон байдал
- Хичээлийн стандарт хөтөлбөрт мэргэжлийн үнэлгээ хийлгэж санал авсан байдал

Онцлог зүйл:

- “Хүнс үйлдвэрлэлийн технологи” бакалаврын хөтөлбөр нийт 130 багц цаг бөгөөд ерөнхий суурь 30.9%, мэргэжлийн суурь 23.9%, мэргэшүүлэх хичээлүүд 45.2%; хөтөлбөрийн онол, дадлагын зохистой харьцааг 4:1 харьцаатай байхаар боловсруулсан. Сургалтын төлөвлөгөөнд тусгасан сонгон суралцах хичээлүүдээс суралцагч нь өөрөө 2-3 кр цагийн нэг хичээлийг сонгон суралцах эрхтэй ба хичээл эхлэхээс 7 хоногийн өмнө сургалтын алба, харьяа тэнхимд мэдэгдэнэ. Гэвч оюутны тоо цөөн байгаагаас сүүлийн жилүүдэд ангиараа нэг хичээлийг сонгож байна.

- Тус хөтөлбөрөөр элссэн суралцагч нь шаталсан сургалтаар техникийн боловсрол эзэмшсэн бол “Кредит дүйцүүлэн тооцох журам” (Захирлын 2011 оны 214 тоот тушаал)-д зааснаар амьтан - 46; ургамал - 47 кредит цагийн хичээлийг өмнө эзэмшсэн боловсролын төгсөлтийн баримт бичгээс дүйцүүлэн тооцуулж, 2.5 жил буюу 5 улирал суралцаж, нийт 130 кредит цуглуулан бакалаврын зэрэгтэй төгсөх боломжтой ба бусад ижил хөтөлбөрөөр төгсөгчидтэй харьцуулахад мэргэжлийн ур чадвар сайн байна.
- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан заавал судлах хичээлүүдийн стандарт хөтөлбөрийн агуулгад ижил чиглэлийн сургууль болон эрдэм шинжилгээний байгууллагуудаас хөндлөнгийн үнэлгээ болон саналыг авч, шинэчлэн сайжруулах ажлыг хийж ирсэн. Одоо сүүлд авсан саналын дагуу стандарт хөтөлбөрөө шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна.
- Суралцагчийн кредит цагийн ачааллыг I курсэд 37 кр; II курсэд 36 кр; III курсэд 33 кр; IV курсэд 24 кр цаг байхаар тус бүр тооцсон нь дипломын төсөл болон улсын шалгалт, судалгаа шинжилгээний ажил хийж гүйцэтгэдэгтэй холбоотой.

Анхаарах асуудал:

- Сургалтын төлөвлөгөөнд ажил олгогч, төгсөгч, суралцагч зэрэг бусад оролцогч талуудын санал, зөвлөмжийг тогтмол тусгах

Дүгнэлт:

“Хүнс үйлдвэрлэлийн технологи” хөтөлбөр нь сургуулийн эрхэм зорилгод нийцсэн сургалтын үйл ажиллагааг явуулдаг бөгөөд хөтөлбөрийн онол, дадлагын зохистой харьцаа 4:1 байгаа нь суралцагчийг мэргэжлийн өндөр ур чадвартай мэргэжилтэн болгон бэлтгэх боломжийг олгодог.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл тус бүрийнхээ CLO-г тодорхойлж хөтөлбөрийн хүрэх үр дүн PLO-г бүрдүүлэхэд хэрхэн холбогдож байгааг нарийн тодорхойлох

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь суралцагч төвтэй, хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын арга зүйн чиглэлээр хийгдсэн ажлууд (“Ээлжит хичээлийг зохион байгуулах арга зүй”; “Шилдэг илтгэл”; “Багш нарын заах аргын ур чадварын уралдаан”; “Хичээл төлөвлөлт”)

- Албан ёсны эрхтэй программ хангамжууд (Moodle, Unimis)
- Цахим хичээл
- Лекц, семинар, лабораторийн хичээлийн төлөвлөлт
- Сургалтын арга зүй, суралцахуйн зорилтот үр дүнгийн уялдаа холбоо гаргасан байдал
- Тестийн сан бүрдүүлэлт
- Дадлагын үнэлгээ
- Суралцагчдийн сэтгэл ханамжийн судалгаа, түүний мөрөөр хийгдсэн ажлууд
- Сургалтын орчин

Онцлог зүйл:

- Moodle системд тухайн хөтөлбөрийн мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлүүдийг цогц байдлаар байршуулан суралцагч цахимаар бие даан сурах боломжийг бүрдүүлсэн.
- Танхимын сургалтыг хүнс судлал, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний олон талт судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэх орчин нөхцөлийг хангасан өөрийн сургуулийн лабораториудыг түшиглэн явуулдаг.

Анхаарах асуудал:

- Цахим сургалтдаа лаборатори хичээлүүдийг хэрхэн үр өгөөжтэй зохион байгуулахад анхаарч ажиллах

Дүгнэлт:

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар нь сургалтыг олон талт сургалт, судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэх орчин нөхцөлийг хангасан өөрийн сургуулийн лабораториудад, мөн Moodle системийг ашиглан суралцагч бие даан сурах боломжийг бүрдүүлсэн сурагцагч төвтэй арга зүйгээр танхимын болон цахим сургалтыг тус тус зохион байгуулдаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Цахим сургалтын лабораторийн хичээлүүдийг суралцагчдад илүү үр өгөөжтэй байдлаар зохион байгуулах, тухайлбал: Moodle системийг улам хөгжүүлэх, лабораторийг виртуал хэлбэрээр зохион байгуулах боломжийг бүрдүүлэх

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ТДС-ийн захирлын холбогдох тушаалууд
- Жил бүр “Оюутны эрдэм шинжилгээний бага хурал” зохион байгуулдаг байдал
- Түвшин тогтоох үнэлгээ
- Хөндлөнгийн үнэлгээ
- Unimis систем
- Суралцагчид, төгсөгчдийн голч дүнгийн судалгаа, дүгнэлтүүд
- Улсын шалгалт, дипломын төсөл хамгаалсан оюутны судалгаа

Онцлог зүйл:

- Сургалтын төлөвлөгөөнд “од”-оор тэмдэглэсэн хүнс үйлдвэрлэлийн технологийн үндсэн хичээлүүдэд оюутан 74(С) үнэлгээнээс дээш дүгнэгдэж тэнцэх ба тэнцээгүй тохиолдолд дараагийн холбоос хичээлийг судлах боломжгүй.
- Суралцагч нь дипломын төсөл бичиж хамгаалах эсвэл улсын шалгалт өгөх хэлбэрээр сонгох боломжтой.

Анхаарах асуудал:

- Хичээл нэг бүрийн үнэлгээний аргуудыг тодорхойлох

Дүгнэлт:

Тус хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчийн мэдлэг, ур чадвар, хандлагаар үнэлэх үйл явцыг журмын дагуу үнэлдэг боловч хичээлүүдийн стандартад хичээл тус бүрээр оюутанд олгох мэдлэг, ур чадвар, хандлагыг бүрэн гаргах үнэлгээний аргуудыг тодорхойлоогүй байна.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- Оюутны мэдлэг, ур чадвар, хандлагыг бүрэн гаргаж үнэлэх төлөвлөгөөний загварыг хичээл тус бүрээр гаргах

ШАЛГУУР 2. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ:

ДҮГНЭЛТ:

Тус хөтөлбөр нь сургуулийнхаа эрхэм зорилгод нийцэж, сургалтын хөтөлбөрийн агуулга нь хичээл хоорондын уялдаа холбоо сайтай, давхардалгүй, онол практикийг зохистой хослуулсан, хэрэгжүүлэх боломжтой зэрэг нь хөтөлбөрийн 2-р шалгуурын /2.1, 2.2/ шаардлагуудыг хангаж, суралцагчийн мэдлэг, ур чадвар, хандлагаар үнэлэх үйл явцыг журмын дагуу үнэлдэг боловч хичээлүүдийн стандартад хичээл тус бүрээр оюутанд олгох мэдлэг, ур чадвар, хандлагыг бүрэн гаргах үнэлгээний аргуудыг тодорхойлоогүй нь 2-р шалгуурын 2.3-ыг хэсэгчлэн хангасан. Иймд хөтөлбөрийн 2-р шалгуурын 3-н шаардлагын 2 шаардлагыг хангасан тул энэ шалгуурыг бүрэн хангаж байна гэж үзэв.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн орчин, сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, технологийн туршилт, дадлагын бааз үйлдвэрүүд, тэдгээрийн тохижилт, багаж төхөөрөмж, тоног хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага, стандартыг хангаж буй байдлыг өөрийн үнэлгээний тайлан, газар дээр нь бодит байдлыг үзэж танилцсан дүн, бусад холбогдох материал нотлох баримтууд, уулзалт ярилцлагын дүнд үндэслэн хөтөлбөрийн 3.1 шалгуурын шаардлагыг **бүрэн хангаж** байна гэж үзэв.

Онцлог зүйл:

- Сургууль нь 13,9 мянган метр эзэмшил газарт байрлах, хичээлийн анги танхим, лаборатори, дадлагын бааз үйлдвэр бүхий 1.8 тэрбум төгрөгийн барилга байгууламжтай. Технологийн цогцолбор сургуулийн бүрэлдэхүүн хэлбэрээр 2016 онд байгуулж 2017 онд НАССР систем нэвтрүүлсэн мах, сүүний үйлдвэр байгуулж, оюутнууд дадлага хийж, судалгаа туршилт гүйцэтгэдэг болсон. Төрийн болон мэргэжлийн холбоодын “Үлгэр жишээ сургалт-үйлдвэрийн лаборатори, дадлагын газартай сургууль”, “Шилдэг менежменттэй сургууль”, “Топ стандарт” сургууль шагналтай.
- Хөтөлбөрт хамаарах бүрэн тоноглогдсон 5 анги кабинет, 9 лаборатори, цайны газар, соёлын заал, 110 суудалтай номын сан, багш ажиллагсдын өрөө, биеийн тамирын заал, боловсон ариун цэврийн өрөө, давхар бүрт ус цэвэршүүлэгчтэй.
- Үндэсний хэмжээнд 2 удаа магадлан итгэмжлэгдсэн биохимийн лабораторид аминхүчлийн бүрдэл, кальци, магни, төмөр, хлор зэрэг эрдэсийн агууламж тодорхойлдог.
- Урсгал засварт жилд 25 сая ₮ төлөвлөж хэрэгжилтийг зохион байгуулдаг. 2017-2022 онд эд хогшил худалдан авахад 12 сая ₮, хичээл үйлдвэрлэлийн дадлагад 38.9 сая ₮ зарцуулсан.
- Цахим хэрэглээний орчныг бүрдүүлж өндөр хурдны утасгүй интернет, шилэн кабель, сургалт, удирдлага мэдээллийн UNIMIS системтэй. Цахим хичээл, контент бэлтгэх, виртуал сургалт, хурал хийх “Цахим сургалтын танхим”-ыг 2021 онд байгуулсан.

Цахим сургалтын Moodle хэсэгт 421 лекц, 328 семинар, 49 лабораторийн хичээл, болон тестийн сантай, тестийн нууцийг хадгалах, өөрчлөн ашиглах боломжтой. Цахим хичээлүүдэд хөндлөнгийн үнэлгээ хийж, дүнд үндэслэн сайжруулалт хийдэг. Сайжруулалтад 2018-2020 онд 1.7 сая₮ зарцуулсан. Цахим систем ашиглах зааварчилгааг оюутны хөтчид тусгасан. Бие даан ажиллах боломжийг хангахад зориулж 1-р давхарт хуваарийн дагуу ашиглах утасгүй сүлжээ, тоноглол бүхий 2 анги тохижуулсан.

- Сэтгэл ханамжийн судалгааг цахим болон цаасан хэлбэрээр 7 бүлэг, 15 заалт бүхий асуултаар нийт багш, оюутныг хамруулан жил бүр, мөн тодорхой чиглэлээр /хичээлээр, багшийг үнэлэх гм/ авч, дүнг тооцож, сайжруулалтыг төлөвлөн хэрэгжүүлдэг.

Анхаарах асуудал:

- 2017-2022 онд ХТПК-ийн 120, ТДС-ийн 15, нийт 135 оюутныг зэргэлдээ сургуулийн дотуур байранд гэрээлэн оруулсан байна.

Зөвлөмж:

- Цаашид өөрийн суралцагсдад зориулсан дотуур байртай болох

Дүгнэлт:

Сургууль нь сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, технологийн туршилт, дадлагын бааз, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин зэргийг, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагуудыг бүрэн хангаж, стандартад нийцсэн хөгжүүлэлт сайжруулалтыг хийдэг тул хөтөлбөрийн 3.1 шаардлагыг бүрэн хангасан.

Үнэлгээ: Бүрэн хангасан

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судагаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Онцлог зүйл:

- Сүүний үйлдвэр нь ариутгасан сүү, исгэлэн сүүн бүтээгдэхүүн (тараг, зөөхий, аарц) болон тослог цагаан идээ (шар тос, цөцгийн тос, хайлмаг) үйлдвэрлэх, махны

үйлдвэр нь махыг шулах, ангилах, боловсруулах, талх нарийн боовны цех нь бүрэн тоноглогдсон, нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн зэрэгцээ оюутнуудын дадлага, судалгааны ажлын баазаар ашиглагддаг.

- Лабораторийн хичээлийн хэвлэмэл 16 гарын авлага нь зорилго, онол, бэлтгэл, арга зүй, үр дүнг тооцох, мэдсэнээ бататгах, шалгах хэсэгтэй. Лабораторийн хичээл, технологийн туршилтыг оюутнууд бие даан гар бие оролцон гүйцэтгэх боломжоор хангагдсан нь практик дадлагатай мэргэжилтэн бэлтгэх давуу талыг бүрдүүлдэг.
- Сүүлийн 6 жилд мэдээллийн технологийн программ хангамжийг сайжруулахад 117.17 сая₮ зарцуулсан, 20 контент, 36 компьютер, 3 нөүтбүүк, 3 проектор, 4 хувилагч, 13 принтер сургалтанд ашигладаг.

Дүгнэлт:

Хүнс үйлдвэрлэлийн технологи мэргэжлээр суралцахад зайлшгүй шаардлагатай иж бүрэн тоноглогдсон шинжилгээний лабораториуд, технологийн туршилтын болон дадлагын бааз үйлдвэрүүд, хичээлийн хэрэгсэл, программ хангамж, түүхий эд материал бусад нөөцөөр тогтмол хангаж, шинэчлэл сайжруулалт хийдэг тул хөтөлбөрийн 3.2 шаардлагыг бүрэн хангасан.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглож, хүнсний аюулгүй байдлын эгзэгтэй цэгийн хяналтын НАССР тогтолцоог нэвтрүүлсэн мах, сүүний үйлдвэр болон талх нарийн боовны үйлдвэрийнхээ бааз ашиглалтыг сайжруулах, тухайлбал: бренд бүтээгдэхүүний хөгжүүлэлт хийх, шинэ технологи дамжуулах, мэргэжлийн дадлага олгох сургалт зохион байгуулах зэргээр нэмэлт орлого олох боломжийг судлан хэрэгжүүлэх.

3.3. Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа

Онцлог зүйл:

- Фонд нь ном сурах бичиг, гарын авлага, сэтгүүл, аудио, видео хичээлийн 13 мянга гаруй нэгж мэдээлэл монгол хэлээр, 1140 нэгж гадаад хэлээр байгаагаас 9479 нь

тухайн хөтөлбөрт хамааралтай, багш оюутнуудад хүртээмжтэй, баяжуулалтад 2017-2022 онд 6 сая₮ зарцуулсан.

- Ховор номыг цахимд шилжүүлэх ажил эхлэсэн.
- Багш нарын болон оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг жил бүр салбарын судлаачид, мэргэжлийн их дээд сургуулийн багш, оюутны дунд нээлттэй зохион байгуулж, илтгэлийн эмхэтгэлүүд, багш оюутнуудын гүйцэтгэсэн судалгааны ажлуудын тайлан зэргийг шинэ мэдээллийн эх үүсвэр болгон ашиглах боломжтой.

Дүгнэлт:

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зориулсан хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрийн хангамж, чанар, хүртээмжид анхаарч, баяжуулалт сайжруулалтыг төлөвлөн хэрэгжүүлдэг тул хөтөлбөрийн 3.3 шаардлагыг бүрэн хангасан.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Цахим номын санг өргөтгөх, бусад сургуулиудтай мэргэжлийн ном, мэдээлэл цахимаар солилцох боломжийг судлах, хөгжүүлэх

ШАЛГУУР 3. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ:

ДҮГНЭЛТ:

Сургууль нь сургалтын орчин, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрийн шалгууруудаар хөтөлбөрийн 3-р шалгуурын /3.1, 3.2, 3.3/ шаардлагуудыг бүхэлд нь бүрэн хангаж байна.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Тус сургууль “сургалт-судалгаа-үйлдвэрлэл” хэв шинжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

- Удирдах зөвлөл, Эрдмийн зөвлөлтэй, Сургуулийн удирдлагын түвшинд захиргааны, сургалт эрдэм шинжилгээний болон санхүүгийн гэсэн 3 албатай.
- 2016 оны 4-р сарын 18-ны өдрийн 02 тоот тогтоолоор “Технологийн дээд сургуулийн дүрэм”-ийг батлан, бүтцийн нэгж хоорондын харилцаа, уялдаа, үйл ажиллагааг хангасан дараах дүрэм, журмуудыг мөрдөж байна. Үүнд:
 - Бодлогын дүрэм журам -5
 - Сургалтын үйл ажиллагаатай холбоотой дүрэм журам -14
 - Оюутан суралцагчидтай холбоотой дүрэм журам-6
 - Багш, ажилтнуудтай холбогдох- 5 журам байна
- Хөтөлбөрийн хороо, Ёс зүйн зөвлөл, Оюутны холбоо, Ахмадын холбоо, Үйлдвэрчний эвлэлийн хороо, Ном сурах бичгийн зөвлөл гэсэн 6 зөвлөл хамтран ажиллаж байна.
- Нийт 48 дүрэм, журмыг сургуулийн веб хуудсанд байршуулсан байна. Мөн эмхэтгэж хэвлэн мэдээлж байна.

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн зорилгоо биелүүлэх хүрээнд холбогдох яам, агентлаг, хяналтын байгууллагууд, их дээд сургууль болон мэргэжлийн холбоодтой, туршлага судлах, хамтран ажиллах талаар байнга холбоотой ажиллаж байна.
- Сургуулийн хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнд сургуулийн эрдэмтэн багш нар (33%)-аас гадна салбарын тэргүүлэх эрдэмтэд (33%), төгсөгчид, ажил олгогчдын төлөөллөөс (34%) хамтран оролцож, хөтөлбөрийг шүүн хэлэлцэх, хөтөлбөрүүдийн нэгдмэл байдал, уялдаа холбоог хангах, тэдгээрийн хэрэгжилтийг хянах, чанарын баталгаажуулалт зэргийг хариуцан ажиллах үүрэгтэй байна.

Дүгнэлт:

- Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагааны үндсэн бүтэц, алба нэгжүүдийн уялдаа болон мөрдөгдөж байгаа дүрэм, журмуудын хэрэгжилтээс тухайн шалгуурын хүрээнд хамаарал бүхий талуудын оролцоог хангаж байна гэж дүгнэв.

Үнэлгээ: Бүрэн хангасан

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагатай хийсэн хамтын ажиллагааны гэрээнүүд
- Аж ахуйн нэгж, байгууллагын захиалгат сургалтууд, хамтран ажилласан сургалтын үр дүн
- Ажил олгогчид, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хийсэн уулзалт, ярилцлага
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр танилцуулсан 6 удаагийн нэвтрүүлэг

Онцлог зүйл:

- Аж ахуйн нэгжүүдэд төрөл бүрийн сургалтыг захиалгаар хийдэг.
- Мэргэжлийн чиглэлийн холбоодтой нягт хамтын ажиллагаатай.
- Гадаад хамтын ажиллагаатай байгууллагуудын тоо жилээс жилд нэмэгдэж, ОХУ, Хятад, Солонгос, Итали, Япон, Казахстан зэрэг орны 13 байгууллагатай хамтран ажиллаж байна.
- Япон улсад оюутнууд дадлага хийдэг болсон нь оюутнуудын мэдлэг чадвар, хандлагад сайнаар нөлөө үзүүлнээс гадна хамт олон, сургуулийн нэр хүндэд эергээр нөлөөлж байна

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн үйл ажиллагааг нийгэмд илүү сайн таниулах, элсэгчдийг татах

Дүгнэлт:

Хамтын ажиллагааны цар хүрээ, түүний үр дүн, мэргэжлийн холбоо, төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага зэрэгт үндэслэн хангалттай гэж дүгнэв.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн нөөц бололцоо, мэргэжлийн чадавхи, бодит практик үйл ажиллагааг нийтэд сайн сурталчилах, нийгэмд үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- 2017-2021 оны “Сургуулийн орлого, зарлагын байдал”, “Санхүүгийн төсөв, гүйцэтгэл”
- Санхүүжилтийн 79.0- 92.7 хувийг оюутнуудын сургалтын төлбөр эзэлж байна.
- Сургууль нь 16 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, 50 гаруй аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллаж байна.

Онцлог зүйл:

- Сургуулийн үндсэн үйл ажиллагааны орлого 2017-2020 онд буурч ирсэн боловч туслах үйл ажиллагааны орлого нэмэгдсэн.
- 2017 онтой харьцуулахад 2020 онд хичээл, үйлдвэрлэлийн дадлагын зардал 30 хувь нэмэгдсэн.
- Нэг оюутанд ноогдох зардлын тооцоо 2017 оноос 2021 он хүртэл 2,2 дахин өссөн.

Анхаарах асуудал:

- Санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх
- Багш, суралцагчийн хөгжилд зарцуулсан зардал буурсан байгааг анхаарах

Дүгнэлт:

- ТДС-ын удирдлага нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн орлогын тогтвортой эх үүсвэртэй, туслах үйл ажиллагаанаас олох орлого нэмэгдэж байна.
- Багш, суралцагчдын сургалтын орчин нөхцлийг сайжруулахад чиглэсэн санхүүжилт хийгдэж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Гэрээт ажил, төсөл хөтөлбөрийг нэмэгдүүлэх
- Эрдэм шинжилгээ, судалгаа, лаборатори, дадлагын газрын ашиглалтыг сайжруулах
- Магадлан итгэмжлэгдсэн лабораторийн үйл ажиллагаанаас олох орлогыг нэмэгдүүлэх
- Сургалтын түшиц үйлдвэрийн “Хан брэнд” бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлэх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- 2019 онд Мексоны 5*5 шинжилгээний аргыг ашиглан гадаад, дотоод орчны шинжилгээ хийсэн байна.
- Стратегийн төлөвлөгөөндөө “Давуу тал, боломжоо ашиглан сул талуудыг арилгах, бэрхшээлийг даван туулах”-аар төлөвлөж, хэрэгжүүлэх арга замаа тодорхойлсон байна.

Анхаарах асуудал:

- Тухайн хөтөлбөрийн хөгжил, тогтвортой байдлыг хангах маркетингийн идэвхжүүлэлт хийх арга зам тодорхойгүй байна.

Дүгнэлт:

Маркетингийн төлөвлөлт хангалттай биш гэж үзээд хэсэгчлэн хангасан үнэлгээ өгөв.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- Тухайн хөтөлбөрөөр төгсөгчийн давуу тал, бодит ур чадварыг сурталчилах
- Хамтран ажилладаг байгууллага, мэргэжлийн холбоод, төгсөгчидөд түшиглэн маркетингийн идэвхжүүлэлт хийх, нийтэд таниулах

Шаардлага:

- Маркетингийн тандан судалгааг тогтмолжуулах, түүнд суурилсан идэвхжүүлэлтийн хөтөлбөр хэрэгжүүлэх
- Маркетингийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, тайлагнах

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Тус сургууль үйл ажиллагаагаа нээлттэйгээр сургуулийн веб, нийгмийн сүлжээний Фэйсбүүк хуудсаар мэдээлж байна.
- Олон нийтийн теле сувгаар 6 удаагийн нэвтрүүлэгт оролцож танилцуулсан.
- Мэргэжил сурталчилах үзэсгэлэнд тогтмол оролцдог.
- Багш, оюутны эрдэм шинжилгээний хурлууд зохион байгуулдаг.
- Сургуулийн танилцах өдөрлөг зохион байгуулдаг.

Дүгнэлт:

Тухайн сургууль, хөтөлбөрийн үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй, ил тод байгаа тул энэ шалгуурыг бүрэн хангасан гэж үзлээ.

Үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 4. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ улс орны хэрэгцээ, салбарын хөгжил, сургуулийн алсын хараа, зорилго зорилтод нийцүүлэн удирдлага, зохион байгуулалтыг хангаж ажилладаг. Сургалтын үйл ажиллагааг хангах тогтсон дүрэм, журамтай, санхүүгийн тогтвортой эх үүсвэртэй, үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөтэй ажиллаж байна. Хэдийгээр хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэл бүрэн хангалттай бус байгаа ч мэдээлэл нь олон нийтэд нээлттэй, ил тод байгаа тул энэ бүлэг үзүүлэлтийн бүрэн хангасан гэж үзлээ.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйлчилгээ

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийн бодлого, дүрэм, журам
- Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Шинэ суралцагсдад зориулсан мэдээлэл, гарын авлага
- Гадаад оюутны элсэлтийн тоо

Онцлог зүйл:

- Жил бүр ерөнхий захирлын тушаалаар элсэлтийн журмыг шинэчлэн баталдаг. Сүүлийн 2 жилд элсэгчдийн 65-90% нь техникийн боловсрол олгох сургуулиас, 22-10% нь бусад сургуулиас, ЭЕШ өгч элсэгч 13-0% байгаад дүгнэлт хийж төлөвлөгөөтэй ажиллаж буй. 2017-2022 онд цогцолбор сургуульд нийт 690 хүүхэд элсэн суралцсанаас ХҮТЭА мэргэжлээр 172, ХҮҮТ мэргэжлээр 133, ХҮТ мэргэжлээр 7, нийт 312 оюутан бакалаврын шатны сургалтад дэвшин суралцсан.
- Элсэгчдийн дундаж оноо 450-530. Сүүлийн 3 жилд бакалаврын 2, магистрын 2, нийт 4 гадаад оюутан элсэн суралцсан.
- Шинэ элсэгчдэд зориулсан хэвлэмэл “оюутны хөтөч” болон цахим гарын авлага гаргаж, зөвлөх багш томилон, мэргэжлийн удирдлага хичээл ордог.
- Шинэ элсэгчдээс /хими/ түвшин тогтоох шалгалт авч, нэмэлт хичээл давтлага зохион байгуулж түвшинг жигдлэн ажилладаг.

Анхаарах асуудал:

- Элсэгчдийн дийлэнхийг өмнө нь тус сургуульд техникийн боловсрол эзэмшсэн хүмүүс эзлэдэг. Гэтэл төгсөөд 2-3 жил мэргэжлээрээ ажиллаад бакалаврт сурах хүсэлтэй хүмүүст заавал ЭЕШ өгсөн байх шаардлага тавьж байгаа нь мэргэжлээрээ шатлан суралцагсдын элсэлтийг бууруулж байна. Ийм шалтгаанаар хүлээгдэж буй хүсэлт гаргасан 79 хүн байна. Асуудлыг холбогдох удирдах байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

Дүгнэлт:

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулж, тэдэнд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн, мэргэжлээрээ шатлан дэвшин суралцах боломж олгож, шинээр элсэгчдийн түвшинг тогтоож, нэмэлт сургалт зохион байгуулах зэрэг суралцагчдад чиглэсэн үйл ажиллагааг хүртээмжтэй, тэдний сонирхолд нийцүүлэн явуулахад анхаарч зохих эрх зүйн баримтыг мөрдөн ажиллаж буй тул хөтөлбөрийн 5.1 шалгуурыг бүрэн хангаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Элсэгчдэд зориулсан сурталчилгааг улам сайжруулан өргөжүүлж, шаталсан сургалттай, мэргэжлийн өндөр дадлагатай мэргэжилтэн бэлтгэхэд зориулсан сургалтын бааз, орчны давуу талуудаа товойлгон сурталчлах.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан
- Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал
- Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан, мэдээ
- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын тайлан мэдээ

Онцлог зүйл:

- Оюутны холбооны үйл ажиллагаанд жилд 300-500 мян.төг төсөвлөн зарцуулсан.
- Оюутанд зөвлөх, тэднийг хөгжүүлэх ажлыг лекц, илтгэлийн уралдаан, оюутны эрдэм шинжилгээний хурал, мэргэжлийн ур чадварын тэмцээн хэлбэрээр тогтмол зохион байгуулдаг.
- Үйлдвэр компанийн захиалгат эрдэм шинжилгээний 8 ажлын судалгаанд 23 оюутныг оролцуулсан. Олон оюутан төгсөлтийн ажлаараа багшийн дэмжлэгтэйгээр судалгаа гүйцэтгэдэг.

Дүгнэлт:

Сургууль нь суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг лекц, илтгэлийн уралдаан, эрдэм шинжилгээний хурал, мэргэжлийн ур чадварын тэмцээн зэрэг сонирхолтой, үр өгөөжтэй хэлбэрүүдээр тогтмол, чанартай үзүүлдэг тул хөтөлбөрийн 5.2 шалгуурыг бүрэн хангаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны клубын зохион байгуулсан арга хэмжээний тайлан мэдээ
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал
- Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл
- Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн тоо, үр дүнгийн мэдээлэл
- Урамшуулал, тэтгэлэг, хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо

Онцлог зүйл:

- Оюутны дунд “СИОН” мэтгэлцээн, “Номын хүч”, “Судлаач оюутан”, Nutrition, “Залуу инженерүүд” клуб, төрөл бүрийн сайн үйлсийн аян зохион байгуулдаг. Үүнд: Дэлхийн хүнсний өдөрт зориулан “Сүү, сүүн бүтээгдэхүүний хандив”, Өндөр настны асрамжийн төвд “Дэм дэмэндээ” аян, “Цусаа хандивлая”, “Миний мөрөөдлийн байшин” эссэ бичлэгийн уралдаан.
- 2018-2022 онд оюутны шагнал урамшуулалд /жилд 1.7-14.0 сая₮/ нийт 37 сая₮ зарцуулсан. 2017 онд 1 элсэгчид 20%, 2019 онд 6 элсэгчид 10%-ийн хөнгөлөлт үзүүлсэн
- 2018-2019 онд олимпиад, уралдаан тэмцээнд амжилттай оролцсон 2 оюутанд 20-40%-ийн хөнгөлөлт үзүүлсэн.
- Олон улсын дадлагажигч оюутан төслийн хүрээнд 1 жилийн хугацаатай үйлдвэрлэлийн Япон улсад хийх дадлагад 2020-2021 онд 15, 2021-2022 онд 15, 2022-2023 онд 8 оюутан хамрагдсан.
- Хичээлийн хуваарийг төлөвлөхдөө бие даан хөгжих, мэргэжлийн чиглэлээр цагийн ажил эрхлэхийг дэмжсэн зохион байгуулалт хийдэг. Төгсөгчид нь ажлын байраар бүрэн хангагддаг.

Дүгнэлт:

Сургууль нь суралцагчдыг олон нийтийн үйл ажиллагаанд татан оролцуулж, тэдний санаачилсан сайн дурын олон хэлбэрийн ажлыг дэмжин хамтран ажиллаж, амжилттай оролцсон оюутнуудыг шагнаж урамшуулах, амжилтыг сурталчлан алдаршуулах, ажилд зуучлах, гадаад оронд дадлагад хамруулах, сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамруулах зэргээр урамшуулан идэвхи санаачлагыг өрнүүлэн ажилладаг тул хөтөлбөрийн 5.3 шалгуурыг бүрэн хангаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа
- Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм, журам

Онцлог зүйл:

- Оюутны шилжилт хөдөлгөөний журамтай. Цогцолбор сургуулийн хэмжээнд 2017-2021 онд 98 оюутан жилийн чөлөө авч, 48 оюутан жилийн чөлөөнөөс ирж, бусад сургуулиас ирсэн 13, шилжсэн 10, сургуулиас гарсан 10, жилийн чөлөөг оролцуулалгүйгээр шилжилт хөдөлгөөн жилд 0.5-12,5% байна.
- Дүйцүүлэн тооцох хичээлийн жагсаалтыг баталж, журмын дагуу ХҮТ мэргэжлээр шатлан суралцагч 47 кредит багц цагийг дүйцүүлэн тооцуулдаг. Үүнийг техникийн боловсрол эзэмшсэнээс хойш 3 жилд эдлэх эрхтэй байдаг. Сүүлийн 6 жилд 3

мэргэжлээр нийт 312 оюутан, үүнээс ХҮТЭА ба ХҮТ мэргэжлээр 179 оюутан дүйцүүлэн тооцоход хамрагдсан байна.

Дүгнэлт:

Суралцагчдын шилжилт хөдөлгөөнд тогтмол судалгаа хийж, дүнд үндэслэн холбогдох зохицуулалтыг хийж, батлагдсан дүрэм, журмын дагуу багц цагийн дүйцлийг тухай бүр шийдвэрлэн ажилладаг тул хөтөлбөрийн 5.4 шалгуурын шаардлагыг бүрэн хангаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн баримт бичгийн загвар
- Баримт бичигт оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байдал
- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм, журмын хэрэгжилтийн байдал

Онцлог зүйл:

- Бакалаврын төгсөлтийн журамтай.
- 2017-2022 онд ХҮТЭА мэргэжлээр 172, ХҮТ мэргэжлээр 27 оюутан төгсөж бакалаврын диплом авсан байна.

Дүгнэлт:

Төгсөлтийн баримт бичиг олгох журамтай, олгож буй төгсөлтийн баримт бичигт оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг зохих эрх зүйн баримтын дагуу бүрэн тусгаж монгол /крилл болон уйгаржин үсгээр/, англи хэл дээр үйлдэж, улсын дугаар бүхий үнэт цаасан дээр өнгөтөөр хэвлэн, холбогдох гарын үсэг, тамга тэмдэг дарж баталгаажуулан бэлтгэсэн байгаа нь хөтөлбөрийн 5.5 шалгуурыг бүрэн хангаж байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 5. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ:

ДҮГНЭЛТ:

Сургууль нь хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулж, тэдэнд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, олон нийтийн ажилд дайчлан оролцуулж, шагнан урамшуулж, шилжилт хөдөлгөөн, багц цагийн дүйцлийг тухай бүр шийдвэрлэж, төгсөгчдөд

стандартын шаардлага хангасан төгсөлтийн баримт бичиг олгож буй тул хөтөлбөрийн 5 /5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5/ шалгууруудыг бүхэлд нь бүрэн хангаж байна.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн чиглэсэн үйлчилгээ

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- ТДС-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны 01 тоот тогтоолоор батлагдсан “Технологийн дээд сургуулийн хүний нөөцийн бодлого” баримт бичиг
- ТДС-ийн захирлын холбогдох тушаалууд
- ТДС-ийн “Багшийн хөгжил” хөтөлбөр 2016-2021
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч доктор багш нарын судалгаа
- Багш суралцагчдын тооны зохистой харьцаа
- Багшийн цагийн ачаалал
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал
- Сүүлийн 5 жилд шагнал хүртсэн багш нарын судалгаа

Онцлог зүйл:

- Мэргэжлийн тэнхимээс шаардлагатай байгаа багшийн тоог тогтоон, сургуулийн захиргаанаас сонгон шалгаруулах зарыг сургуулийн цахим хуудас, телевиз, төвийн сонин хэвлэлээр дамжуулан түгээж, багш шалгаруулан авах журмын дагуу зохион байгуулдаг. Сонгон шалгаруулалтанд оролцогчдын бичиг баримтыг хянан ярилцлаганд оруулж, тэнцсэн тохиолдолд мэргэжлийн болон гадаад хэл, ур чадварын шалгалтуудыг авч, тэнцэгсдээс шаардлагатай ажилтныг ажилд авч, бусдыг нь нөөцөд бүртгэдэг. Нөөцөд байгаа ажил горилогчдын судалгааг ерөнхий эрдмийн багш, мэргэжлийн багш, ажилчин зэргээр төрлжүүлэн хүний нөөцийн санг бүрдүүлэн ажиллаж байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн багш нарыг ажилласан жилээр нь авч үзвэл 38.5 % нь тус сургуульд 21-ээс дээш жил, 23% нь 10-20 жил ажилласан туршлагатай болох нь харагдаж байна.
- ТДС-ийн “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд сургалтын үйл ажиллагаа; эрдэм шинжилгээ судалгааны ажил; сургууль олон нийтийн ажил 3 чиглэлээр үнэлэн албан тушаалын зэрэглэлийг тогтоодог. Багш нарын 61.5% ахлах багш, 30.8% дэд профессор, 7.7% профессор гэсэн 3 зэрэглэлд ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд 1 багш ахлах багш, 1 багш дэд профессор, 1 багш профессор багш зэрэглэлд дэвшин ажилласан байна.

- Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхим нь үндсэн 13 багштай, 46.1% нь докторын зэрэгтэй. Үүнээс мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээл заадаг багш нарын 46.4% нь доктор. Багшийн жилийн цагийн ачаалал 18 багц цаг бөгөөд сургалтын болон эрдэм шинжилгээний гэсэн 2 хэсгээс тогтоно. А, Б цагийн харьцаа багшийн зэрэглэлээс хамаарна. Багш нэг улиралд 3, хичээлийн жилд 6 төрлийн хичээл заадаг ба багш бүр илүү цагийн мөнгө авдаг. Багшийн ажлыг сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаагаар нь үнэлж, урамшуулдаг.

Дүгнэлт:

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарийн 46.1% нь докторын зэрэгтэй, 38.5 % нь тус сургуульд 21-ээс дээш жил, 23% нь 10-20 жил ажилласан мэргэжлийн туршлага, өндөр ур чадвар бүхий хамт олон байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- ТДС-ийн стратеги төлөвлөгөө
- “Багшийн хөгжил” хөтөлбөр 2016-2021
- ТДС-ийн хичээлийн жилийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө
- Тэнхимийн ажлын төлөвлөгөө
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн хавтас
- Тэнхимийн хичээлийн жилийн улирал бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан (2017-2022)
- Мэргэжил дээшлүүлэлтийн судалгаа, тайлан
- Нээлттэй, үзүүлэх, хамтарсан, тайлант хичээлийн мэдээ

Онцлог зүйл:

- ТДС-ийн “Багшийн хөгжил” хөтөлбөрийг 2016-2021 онуудад 3 үе шаттайгаар хэрэгжүүлсэн ба 2022-2023 оны хичээлийн жилээс улам боловсронгуй болгож, багш нарын мэргэжлийн болон сургалтын заах арга технологи, гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр төрөлжүүлэн төлөвлөж, үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.

- Сүүлийн 5 жилд уг хөтөлбөрт мэргэшүүлэх болон мэргэжлийн суурь хичээл заадаг багш нарын сургалтын арга зүй, харилцаа, хандлага, төлөвшлийн чиглэлээр сургууль дээрээ 17 сургалт зохион байгуулсан, дотоодод давхардсан тоогоор 8, гадаадад 6 багш мэргэжил дээшлүүлсэн байна. Гадаадад мэргэжил дээшлүүлсэн багш нар БНХАУ болон ОХУ; БНСУ-д мэргэжлийн сургалтад хамрагдсан байна.

Анхаарах асуудал:

- Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах хувь хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарах

Дүгнэлт:

Тус хөтөлбөрийн багш нар “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн болон сургалтын арга зүй, харилцаа, хандлага, төлөвшлийн чиглэлээр сургалтуудад хамрагдсан бөгөөд нийт багш нарын 46-61% байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Гадаад болон дотоодод сургалт семинарт хамрагдсан багш нарын сургалтын үр дүн, ахиц дэвшлийг үнэлдэг байхаас гадна үзүүлдэг дэмжлэг, урамшууллыг тодорхой болгох

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо
- Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн үр дүн
- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал

Онцлог зүйл:

- “Хүнс үйлдвэрлэлийн технологи” хөтөлбөрт хичээл заадаг багш нар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, сүүлийн 5 жилд нийт 16 оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийж, инновацийн технологийг нутагшуулах ажилд оролцон ажиллаж байна. Энэ хугацаанд шинжлэх ухаан технологийн болон инновацийн 6 төсөл, захиалгат болон гэрээт 19 ажлыг амжилттай гүйцэтгэсэн ба БНХАУ-ын Зүүн хойд бүсийн хөдөө аж ахуйн их сургуулийн судлаачдын багтай хамтран “Хятад

болон Монгол улсын сарлагийн сүү, сүүн бүтээгдэхүүнээс ялгасан пептидийн синтезийн механизм ба зохицуулах үйлчлэлийн судалгаа” (2023-2025) сэдэвт ШУТ-ын хамтарсан төслийн санал боловсруулж, холбогдох материалуудын хамт Монгол улсын Шинжлэх ухаан технологийн санд хүргүүлээд байна.

- Жил бүр багш оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, судалгааны ажлын үр дүнг шүүн хэлэлцдэг ба тайлант хугацаанд нийт дотоодод 99, гадаадад 30 гаруй өгүүлэл тус тус нийтлүүлж олны хүртээл болгосон. Импакт фактор өндөртэй сэтгүүлд 15 өгүүлэл нийтлүүлж, нийтдээ 258 удаа эшлэгдсэн байна.
- Багш бүр өөрийн заадаг хичээлийн лабораторийн ажлын аргачлалыг 6 ном, 31 гарын авлага болгон хэвлэж, сургалтад ашигладаг. Цахим хичээлийн хүрээнд MOODLE программыг ашиглаж байна.

Дүгнэлт:

“Хүнс үйлдвэрлэлийн технологи” хөтөлбөрт хичээл заадаг багш нар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүнгээр дотоодод 99, гадаадад 30 гаруй өгүүлэл үүнээс импакт фактортай сэтгүүлд 15 өгүүлэл тус тус нийтлүүлж, нийтдээ 258 удаа эшлэгдэн олны хүртээл болгосон.

Үнэлгээ: Бүрэн хангасан

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- ТДС-ийн захирлын холбогдох тушаалууд
- “Багшийн хөгжил” хөтөлбөр 2016-2021
- Тэнхимийн хичээлийн жилийн улирал бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан (2017-2022)
- Багшийн ажлын дэвтэр
- Багш нарын нээлттэй хичээлд суусан багшийн тэмдэглэл 2017-2022 он
- Багш нарын хичээлд суусан багш нарын тэмдэглэл 2017-2022 он
- Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаа

Онцлог зүйл:

- Хичээлийн жилийн төгсгөлд багш бүр өөрийн үнэлгээний тайланг бичиж, тэнхим болон сургалтын албаар хэлэлцүүлэн үнэлүүлдэг. Багшийн хөндлөнгийн үнэлгээг ТДС-ийн “Багшийг аттестатчилах журам”, “Багшийн ажлыг үнэлж дүгнэх журам”-ын дагуу мэргэжлийн болон сургалтын арга, заах арга, технологи, гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зэрэг шалгууруудаар үнэлдэг. Шалгуур

үзүүлэлтийн цуглуулбал зохих онооны 90-100%-ийг хангасан багшид цалингийн 80%-иар, 80-89%-ийг хангасан багшид цалингийн 60%-иар нэмэгдэл олгодог ба 50%-иас доош үнэлэгдсэн багшийн цалингийн 30 хүртэл хувийг хасах буюу хөдөлмөрийн гэрээ цуцлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг байна.

- 2017-2022 оны хичээлийн жилд давхардсан тоогоор 8 багш сургалтад хамрагдаж, сургахуйн чадвараа дээшлүүлж, чадамжийн түвшинг үнэлүүлсэн 3 багш зэрэглэлээ ахиулсан байна.
- Багшийн ажлын хөндлөнгийн үнэлгээг оюутнуудаас улирлын эцэст тухайн улиралд үзсэн хичээлийг агуулга, заасан багш, эзэмшсэн мэдлэг, чадварын талаар сэтгэл ханамжийн судалгааг авдаг. Улирлын төгсгөлд оюутан хичээл заасан багшийг үнэлэх ба судалгааны дүнгээс харахад хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарт өгсөн үнэлгээний сэтгэл ханамж 60-80 хувьтай байна.

Дүгнэлт:

Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар нь хичээлийн жил бүр өөрийн үнэлгээний тайлан бичиж тэнхим болон сургалтын албаар хэлэлцүүлэх ба хөндлөнгийн үнэлгээг оюутнуудаас улирлын эцэст сэтгэл ханамжийн судалгааг авч, үр дүнг тооцдог.

Үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 6. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ:

ДҮГНЭЛТ:

“Хүнс үйлдвэрлэлийн технологи” хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим нь олон жил тасралтгүй ажилласан мэргэжлийн туршлага бүхий багшлах бүрэлдэхүүнтэй, багш нарынхаа мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, урамшуулах, дэмжлэг үзүүлэх бодлого баримтлан төлөвлөж хэрэгжүүлдэг, үр дүнг үнэлэн тасралтгүй сайжруулах зарчим бүхий тогтолцоо бүрдсэн нь тус шалгуурын /6.1, 6.2, 6.3, 6.4/ шаардлагуудыг бүрэн хангаж байна гэж үзэв.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- 2012 онд баталсан “Сургуулийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх журам”

- 2015 онд байгуулагдсан "Ёс зүйн зөвлөл"
- Сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан /2018-2022 онууд/
- "Чанарын удирдлагын гарын авлага"
- Дотоод хяналтын ажилтны жил бүрийн төлөвлөгөө, тайлан
- Багш нарын үнэлгээ /сүүлийн 3 жилийн байдлаар/
- Ажил олгогчоос авсан сэтгэл ханамжийн судалгаа / 2022 он, ажил олгогчдийн уулзалт/
- Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаа

Онцлог зүйл:

- 2013 оноос "Чанарын удирдлагын гарын авлага" боловсруулан, мөрдөж чанар, дотоод хяналт хариуцсан орон тооны бус ажилтантай байсан бол 2022 оноос орон тооны ажилтантай болсон.
- Захиргааны зөвлөлийн хурлаар ажлын үр дүнг хэлэлцэн, зохих арга хэмжээг тогтмолжуулсан
- Хичээлийн хөтөлбөрүүдэд мэргэжлийн болон боловсролын зэрэгтэй хүмүүсээр үнэлгээ хийлгэдэг.
- Оролцогч талуудаас (суралцагч, багш, удирдлага, ажил олгогч, төгсөгч) сэтгэл ханамж, хөтөлбөрийн үнэлгээний судалгаа авч өөрчлөлт, сайжруулалтыг тогтмол хийдэг. Хичээлийн улирал бүр суралцагчдаас сургалтын үйл ажиллагаа, орчин, багшийн ёс зүйтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгаа авч үнэлдэг.

Анхаарах асуудал:

- Чанарын тогтолцооны гарын авлагад эрсдэл, үл тохирлыг хэрхэн үнэлэх, тодорхойлох талаар мэдээлэл байхгүй.

Дүгнэлт:

Тус сургууль нь үйл ажиллагаандаа дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээг жил бүр хийж байна. Хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах үйл явцын чанарыг хангах алба байгуулагдсан бөгөөд "Чанарын удирдлагын гарын авлага"-ыг мөрдлөг болгон, үйл ажиллагаагаа сайжруулахад тусган ажиллаж байна..

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Чанарын гарын авлагыг Чанарын менежментийн тогтолцоо, Дотоод чанарын баталгаажуулалтын шаардлагад нийцүүлэн сайжруулах

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- ТДС-ийн төгсөгчид, төгсөгчдийн ажил эрхлэлт, төгсөгчдийн амжилт бүртгэлийн мэдээллийн сан <http://itech.edu.mn/mn/index.php?pid=34>
- Сургуулийн вэб сайт, фейсбүүк хуудас, мэдээллийн самбар
- Төгсөгчдийн мөшгөх судалгаа
- Төгсөгчдийн уулзалтын тайлан

Онцлог зүйл:

- “Төгсөгчдийн холбоо”-г байгуулж, төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал, амжилт зэргийг бүртгэлжүүлсэн, баяжуулалт хийдэг. Эргэх холбоо сайтай.
- Суралцагч оюутнуудыг цалинтай дадлага хийлгэх, цагийн ажилтнаар ажиллуулах уян хатан цагийн зохицуулалт хийж, төгсөөд ажлын байраар хангадаг.

Анхаарах асуудал:

- Аж үйлдвэржилтийн хөгжил, дэвшилтэй холбоотой ажил олгогчдын шаардлагад төгсөгчийн мэдлэг, ур чадварын нийцсэн эсэх талаар судалгаа авч, хөтөлбөрийн сайжруулалтыг хийдэг ч гарсан үр дүнг дахин үнэлэхгүй байгааг анхаарах

Дүгнэлт:

Хүнс Үйлдвэрлэлийн Технологи хөтөлбөрөөр төгсөгч нь ажил олгогчдын шаардлагад нийцсэн ур чадвар, мэдлэг эзэмшсэн бөгөөд сургуультайгаа нягт уялдаа холбоотой ажиллаж хөтөлбөр сайжруулалтанд санал нь тусгагддаг байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сайжруулсан үйл ажиллагааны бүртгэлийг хөтөлж, дахин үнэлгээ хийх

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Ази номхон далайн бүс нутгийн /APACC/-ын магадлан итгэмжлэлийн шалгуурыг хангаж 2013 онд Мөнгөн медаль хүртсэн.
- APACC-аар магадлан итгэмжлэгдсэн сургуулиудын холбооны удирдах зөвлөлийн гишүүн (Малайз, Филиппиний 6 сургууль болон Монгол улсыг төлөөлж Технологийн дээд сургууль)
- 1995 онд Хүнсчдийн холбооны гишүүн

- 2015 онд БМИҮЗ-ийн үндсэн гишүүн
- 2016 онд хувийн их дээд сургууль, коллежуудын холбооны гишүүн
- 2012 онд БМИҮЗ-ийн 132 тоот тогтоолоор Хүнс үйлдвэрлэлийн технологи хөтөлбөр 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн “Гэрчилгээ”
- Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа 86 их дээд сургуулиудын чансааг тогтоосон 50 сургуулийн жагсаалтын А үнэлгээнд багтаж ижил төсөөтэй сургалтын үйл ажиллагаа явуулдаг сургуулиадаас 2-рт эрэмбэлэгдсэн амжилт

Онцлог зүйл:

- ТДС болон “World useful” ХХК-тай хамтран Хүнс Үйлдвэрлэлийн Технологи мэргэжлийн оюутнууд Япон улсад 1 жилийн хугацаатай дадлага хийж, мэргэжлийн ур чадвараа нэмэгдүүлэх, бусад орны соёлтой танилцах боломжтой болсон. Өнгөрсөн хугацаанд 30 оюутан хамрагдсан бөгөөд Сэтгэл ханамжийн судалгаагаар 87% нь маш сайн үнэлгээ өгч цаашид үргэлжлүүлэн хамтран ажиллаж байна.
- Салбарын мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж, хөтөлбөрийн сайжруулалтанд тэдний саналыг тусган ажилладаг.

Дүгнэлт:

Тус сургууль Улсын болон Олон Улсын мэргэжлийн холбоод, байгууллагуудын гишүүнээр элсэж, хамтран ажилладаг ба салбарын эрдэмтэд, ажил олгогчдоос хөтөлбөрийн сайжруулалтанд санал авч, зөвлөмжийг тусгадаг. Төгсөгчид нь мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрөгдөж үр дүнтэй ажиллаж байна. Гадаад дотоодын хамтын ажиллагааны үр дүнд сургалтын орчны сайжруулалт, хичээлийн хэрэглэгдэхүүний баяжуулалт хийснээр суралцагчид судалгаа, шинжилгээний ажил хийх боломжийг нэмэгдүүлсэн байна. Суралцагчид нь олон улсын уралдаан тэмцээнд оролцож амжилт үзүүлдэг байна.

Үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 7. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ҮНЭЛГЭЭ:

ДҮГНЭЛТ:

Тус сургууль “Чанарын удирдлагын гарын авлага” боловсруулж, байгууллагын үйл ажиллагаа, хөтөлбөрийн хэрэгжүүлэлтэнд мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн чанарын баталгаажуулалтанд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж (суралцагч, төгсөгч, багш ажилтан, ажил олгогч) сэтгэл ханамжийн судалгаа авч, хөтөлбөрийн сайжруулалтыг хийдэг. Улсын болон Олон улсын байгууллагуудад хүлээн зөвшөөрөгдөж, хамтран ажилладаг ба суралцагчид, төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны эрэлт сайн байна.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: БҮРЭН ХАНГАСАН

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	+			
2	Сургалтын үйл ажиллагаа	+			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	+			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	+			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	+			
6	Багшийн үйл ажиллагаа	+			
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	+			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

/Нэгдсэн зөвлөмжид дээрх зөвлөмж, шаардлагыг шууд тусгахгүйгээр агуулгыг нэгтгэн сургуулийн удирдлага, хөтөлбөрийн баг бодитой хэрэгжүүлж, үр дүнд хүрэх боломжтойгоор томъёолж боловсруулсан байна/

Сургуулийн нэр	Технологийн дээд сургууль
Хөтөлбөрийн нэр	“Хүнс үйлдвэрлэлийн технологи”
Хөтөлбөрийн индекс	072104
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрт оролцогч талуудын санал асуулгыг тогтмолжуулах, эрэлт хэрэгцээнд суурилан хөтөлбөрийн сайжруулалтын байнга хийдэг байх - Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, төгсөгчийг мөшгөх судалгааг тогтмолжуулах, оролцоог сайн хангах
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл тус бүрийнхээ CLO-г тодорхойлж хөтөлбөрийн хүрэх үр дүн PLO-г бүрдүүлэхэд хэрхэн холбогдож байгааг нарийн тодорхойлох - Цахим сургалтын лабораторийн хичээлүүдийг суралцагчдад илүү үр өгөөжтэй байдлаар зохион байгуулах, тухайлбал: Moodle системийг улам хөгжүүлэх, лабораторийг виртуал хэлбэрээр зохион байгуулах боломжийг бүрдүүлэх - Оюутны мэдлэг, ур чадвар, хандлагыг бүрэн гаргаж үнэлэх төлөвлөгөөний загварыг хичээл тус бүрээр гаргах
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Цаашид өөрийн суралцагсдад зориулсан дотуур байртай болох - Орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглож, хүнсний аюулгүй байдлын эгзэгтэй цэгийн хяналтын НАССР тогтолцоог нэвтрүүлсэн мах, сүүний үйлдвэр болон талх нарийн боовны үйлдвэрийнхээ бааз ашиглалтыг сайжруулах, тухайлбал: бренд бүтээгдэхүүний хөгжүүлэлт хийх, шинэ технологи дамжуулах, мэргэжлийн дадлага олгох сургалт зохион байгуулах зэргээр нэмэлт орлого олох боломжийг судлан хэрэгжүүлэх.

	<ul style="list-style-type: none"> - Цахим номын санг өргөтгөх, бусад сургуулиудтай мэргэжлийн ном, мэдээлэл цахимаар солилцох боломжийг судлах, хөгжүүлэх
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн нөөц бололцоо, мэргэжлийн чадавхи, бодит практик үйл ажиллагааг нийтэд сайн сурталчилах, нийгэмд үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх - Гэрээт ажил, төсөл хөтөлбөрийг нэмэгдүүлэх - Эрдэм шинжилгээ, судалгаа, лаборатори, дадлагын газрын ашиглалтыг сайжруулах - Магадлан итгэмжлэгдсэн лабораторийн үйл ажиллагаанаас олох орлогыг нэмэгдүүлэх - Сургалтын түшиц үйлдвэрийн “Хан брэнд” бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг нэмэгдүүлэх - Тухайн хөтөлбөрөөр төгсөгчийн давуу тал, бодит ур чадварыг сурталчилах - Хамтран ажилладаг байгууллага, мэргэжлийн холбоод, төгсөгчидөд түшиглэн маркетингийн идэвхжүүлэлт хийх, нийтэд таниулах - Маркетингийн тандан судалгааг тогтмолжуулах, түүнд суурилсан идэвхжүүлэлтийн хөтөлбөр хэрэгжүүлэх - Маркетингийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, тайлагнах
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Элсэгчдэд зориулсан сурталчилгааг улам сайжруулан өргөжүүлж, шаталсан сургалттай, мэргэжлийн өндөр дадлагатай мэргэжилтэн бэлтгэхэд зориулсан сургалтын бааз, орчны давуу талуудаа товойлгон сурталчлах
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Гадаад болон дотоодод сургалт семинарт хамрагдсан багш нарын ажлын үр дүн, ахиц дэвшлийг үнэлдэг байхаас гадна үзүүлдэг дэмжлэг, урамшууллыг тодорхой болгох
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> - Чанарын гарын авлагыг Чанарын менежментийн тогтолцоо, Дотоод чанарын баталгаажуулалтын шаардлагад нийцүүлэн сайжруулах - Сайжруулсан үйл ажиллагааны бүртгэлийг хөтөлж, дахин үнэлгээ хийх

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Технологийн дээд сургуулийн “Хүнс үйлдвэрлэлийн технологи” 072104 хөтөлбөрийг

БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “**ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН**” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Т.Амаржаргалан/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Б.Буянчимэг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Г.Оюун/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Э.Баярмаа/

IV.Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нартай хийх уулзалт

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилл асан жил	Заадаг хичээл
1	Цэдэндамба Доржсүрэн	дэд профессор	доктор (Ph.D)	19	Биотехнологич
2	Баярлах Даваасүрэн	ахлах багш	Магистр (M.Sc)	19	Химийн багш
3	Нагааранз Чимэгээ	профессор	доктор (Ph.D)	14	Мах, сүүний үйлдвэрийн технологич
4	Ядамсүрэн Баярхүү	дэд профессор	доктор (Ph.D)	30	Үр тариа боловсруулах үйлдвэрийн инженер технологич
5	Отгонбаатар Энхзул	дэд профессор	доктор (Ph.D)	5	Химич, экологи химич
6	Пүрэвсүрэн Байгалмаа	ахлах багш	доктор (Ph.D)	5	Хүнсний технологич
7	Монголбаяр Мөнхцэцэг	ахлах багш	Магистр (M.Sc)	14	Талх чихрийн үйлдвэрийн инженер технологич
8	Пүрэвдорж Өлзий-Орших	ахлах багш	Магистр (M.Sc)	4	Хүнсний биотехнологич
9	Пүрэвдорж Алтанцэцэг	ахлах багш	Магистр (M.Sc)	27	Хөргөлтийн инженер
10	Бадарч Гэрэлмаа	ахлах багш	магистр (M.Sc)	16	Иргэний ба үйлдвэрийн барилгын инженер
11	Отгонбаатар Оргил-Эрдэнэ	ахлах багш	магистр (MSc)	14	Математикийн багш
12	Сүхбаатар Нарандэлгэр	дэд профессор	доктор (Ph.D)	20	Талх чихрийн үйлдвэрийн инженер технологич
13	Бат-Утга Энхцэцэг	ахлах багш	Магистр (M.Sc)	12	Талх чихрийн үйлдвэрийн инженер технологич

III. Ажил олгогчидтой хийх уулзалт

№	Овог нэрс	Ажлын газар	Албан тушаал	Утас
1	М.Дуламсүрэн	Витафит -милк ХХК	Ахлах технологич	91925669
2	М.Нармандах	Монголын хүнсчдийн холбоо	МХХ-ны гүйцэтгэх захирал	95051162
3	Б.Гэрэлчулуун	Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар	ХАБ хариуцсан ахлах мэргэжилтэн	96007171
4	Б.Даваасүрэн	СХЗГ	Ахлах мэргэжилтэн	99058172
5	Отгонбаатар	Хурх гурил	Үйлдвэрийн дарга	99017803
6	Б.Болормаа	Траст трэйд ХХК	Үйлдвэрийн дарга	95097502
7	Б.Оюунтуяа	Хүнс комплекс ХХК	Захирал	99090862
8	В.Оюунтуяа	Траст трэйд ХХК	Мастер, технологич	88285447
9	Бадамгарав	Талх чихэр ХК	Лабораторийн эрхлэгч	88789388
10	Мягмарсүрэн	Сүү ХК	Технологич	88095046
11	М.Цэрэнбадам	ЖЕМ интернэйшнэл	Ерөнхий технологич	98123360
12	Н.Эрдэнэбилэг	UFC Трейд ХХК	Ерөнхий технологич	
13	Б.Отгон	Монкек ХХК	Ерөнхий технологич	91013241
14	Оюундарь	“Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ	Эрүүл ахуйч	99047415

IV. Төгсөгчидтэй хийх уулзалт

№	Овог нэрс	Төгссөн он	Ажлын газар	Албан тушаал
1	Ц.Молор-Эрдэнэ	АПУ дэйри	Ахлах технологич	88409378
2	Бямбацэрэн	ТЕСО ХХК	Технологич	88720427
3	Баярмаа	Сүү ХК	Чанар	99889874
4	Оюунгэрэл	Атар-Өргөө ХХК	Технологич	99061916
5	Оюун-Эрдэнэ	Жүр-Үр ХХК	Ахлах ажилтан	88040825
6	Х.Халиунаа	Жин Туул ХХК	Технологич	99297913
7	Б.Даваасүрэн	Тесо ХХК	Ерөнхий менежер	88107280
8	Г.Дуламжав	ХТПК	Талх, нарийн боовны технологийн багш	88005731
9	Б.Солонго	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Бялуу үйлдвэрлэгч	88024143
10	Б.Үүрцайх	Баянхонгор аймаг, "Өлзийт" ХХА-н МСҮТ төв	Сүү боловсруулах технологийн багш	80591994
11	Э.Наранзул	Жүр үр ХХК	Магистрант	95043883
12	Ц.Баярсайхан	Жүр үр ХХК	Брэнд цехийн ахлах ажилтан	88871786
13	М.Мөнхсайхан	Үндсэн хүнс ХХК	Технологийн ажилтан	88461666
14	Н.Золгэрэл	GN Beverages ХХК	Технологийн ажилтан	88481828

V.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ

210136 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Үйлдвэрийн гудамж 26, Утас/факс: (976-11)341616
И-мэйл: foodtech@foodtech.edu.mn
http://www.itech.edu.mn

2023.04.12 № 29
танай _____ -ны _____ -т


Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлд

Бакалаврын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагын дагуу тус сургууль нь "Хүнс үйлдвэрлэлийн технологи" (072104), "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи" (072105) хөтөлбөрөөр өөрийн үнэлгээний тайлангаа бичиж, магадлан итгэмжлүүлэх хүсэлтээ өгсний дагуу шинжээчдийн баг үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийж, өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримтуудтай танилцан, ажил олгогчид, төгсөгчид, суралцагчдын төлөөлөл, багш ажилтнуудтай уулзалт зохион байгуулан ажилласан юм. Бид шинжээчдийн багийн үнэлгээний тайлантай танилцлаа.

Тус шинжээчдийн багийн үнэлгээний тайлангийн дүгнэлттэй санал нэг байна. Цаашид бид шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийн дагуу Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний багш нарын эрдмийн зэрэг цолыг ахиулах, хөтөлбөрийн маркетинг идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсронгуй болгох зэргээр үйл ажиллагаандаа сайжруулалт хийн ажиллах болно.

Бидний үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөн тусалж ажилласан БМИҮЗ-ийн хамт олон болон шинжээчдийн багийн бүрэлдэхүүндээ талархал илэрхийлж ажлын амжилт хүсье.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Б.БАТ-ЭРДЭНЭ

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан(огноо)

[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Зөвлөмж....

Шаардлага

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан(огноо)

[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Зөвлөмж....

Шаардлага

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа